



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 02 дугаар сарын 12

№01119 ДЧА-2018/4/СТА-ОНТС Мандалговь хот

Г

Зөрчил арилгуулах тухай

Т

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Ажилчдад олгох орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгийг Сум хөгжүүлэх сангийн дансанд байршуулсан.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.4-д /Энэ журмын 1.3-т заасан дансанд сангийн хөрөнгоос бусад хоронго байршиуулахыг хориглоно./ гэж заасныг зөрчсөн байна.

2. Сум хөгжүүлэх сангаас зээл авсан Б.Эрдэнэбаатар, Г.Энхтайван нар хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт хийгээгүй, гэрээний үүрэг зөрчсөн байхад гэрээг сунгаж, эргэн төлөлтийн хуваарыт өөрчлөлт оруулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.6.2-д /зээлийн хугацаа нь 36 хүртэл сар байна/, 4.2.2-д /сум хөгжүүлэх болон жисижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хугацаа хээтэrsэн зээлийн өргүй байх/, 6.1-д /Сангаас зээл авсан этгээд зээлийг үр ашиггүй зарцуулсан буюу зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн болон барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдоло тухайн этгээдэд сангаас дахин зээл олгохгүй./ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн толборийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор толборийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.5-д /Байгуулсан гэрээ, хэлцэл мөрдөж байгаа

хууль тогтоомжс, дүрэм, журмын шаардлага, нохилийг хангаагүй/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Ажилчдад орон сууцны хөнгөлөлттэй зээл олгох зориулалттай хөрөнгийг сүм хөгжүүлэх сангийн данснаас татан авч, цаашид тус дансанд сангийн хөрөнгөөс бусад хөрөнгө байршуулахгүй байх;
2. Б.Эрдэнэбаатар, Г.Энхтайван нарын зээлийн үлдэгдлийг анх зээл авсан хугацаанаас эхлэн нийт 36 сараас ихгүй хугацаанд зээлийг төлж барагдуулахаар тооцож, сар бүр үндсэн төлбөр төлүүлэхээр хуваарийг шинэчлэх;
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянжаргалан сумын Засаг дарга Г.Туяа, нягтлан бодогч Ц.Наранжаргал нарт даалгав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН<sup>1</sup>:


АХЛАХ АУДИТОР



Ч.БЭРХСАЙХАН

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАСАГ ДАРГА



НЯГТЛАН БОДОГЧ

Ц.НАРАНЖАРГАЛ

<sup>1</sup> Албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зорчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хургуулна/